

**ТЯНЬЗИН ХОТ, МОНГОЛ УЛСТАЙ ЭДИЙН
ЗАСАГ, ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛА-
ГААГ ХӨГЖҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ**

Лян Жили*

80-аад оноос улс орнууд эдийн засгийн талаар харилцан хамаарах явдал улам бүр гүнзгийрч, эдийн засгийн хөгжил интеграцчилах төвшин улам дээшлэх боллоо. Дэлхийн улс орнуудын үйлдвэрлэлийн бүтэц төгөлдөржин, олон улсын хөдөлмөрийн хуваарь шинэ шатанд гарч байна. Дэлхийн эдийн засаг бүсчлэн хуваагдах хандлага хүчтэй болж, өнөөгийн дэлхийн эдийн засгийн хөгжлийн гол чиг хандлага болж ирлээ.

Ойрын жилүүдэд Зүүн хойд Азийн (ЗХА) бүс нутгийн улс төрийн байдалд томоохон өөрчлөлт гарч байгаа боловч эндхийн улс төр, эдийн засгийн байдал харьцангуй түвэгтэй хэвээр, нийгмийн байгуулал харилцан адилгүй, хөгжлийн төвшин ялгаатай, дээр нь бас томоохон орнуудын ашиг сонирхлын зөрөлдөөн зэрэг нь гүнзгий интеграцчиллыг бий болгож чадахгүй, гагцхүү хоёр ба олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хүрч байна. Энэ бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа, шинжлэх ухаан техникийн солилцоо, худалдаа жилээс жилд нэмэгдсээр байна.

Манай улс (Хятад Орч.) ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцох явдлыг шатрын хөлөг дээр тоглох лугаа адил үзэж, бүхий л давуу талыг дайчлах хэрэгтэй. Алив муж, хот нь давуу талаа түшиглэн улсын эрх ашгийн үүднээс зохих хөдөлмөрийн хуваарийн дагуу харилцан дутуугаа нөхөх, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр хүч чармайлт гарган хамтран ажиллах нийтлэг үндэслэлийг олж авууштай. Энэхүү өгүүлэлд Монгол улстай хамтран ажиллах боломж, хэрэгжүүлэх арга замыг голчлон авч үзлээ.

**Нэг. Бүхий л давуу талаа дайчлан
Монгол улстай хамтын ажиллагаагаа
хөгжүүлэе**

Манай улсын Шар мөрөн, Бохайн тэнгисийн бүс нь ЗХА-ийн төв хэсэгт оршдогийн хувьд түүх, газарзүйн аль ч талаас авч үзсэн Тяньзин хот энэ бүсэд онцгой чухал үүрэгтэй бөгөөд Монголтой хамтын ажиллагаа хөгжүүлэхэд ч өөрийн давуулаг байдлаа Бээжин, Өвөрмонгол, Хэбэйтэй хавсран нэгтгэвэл байгалиас заяасан асар их бололцоог дайчилж болох юм.

1. Тяньзин нь нийслэл Бээжинг хаяа дэрлэн оршдог. Бээжин бол Хятадын улс төр, соёлын төв, олон улсын харилцааны зангилаа, бас Хятадын хамгийн их мэдээлэл хуримталсан билээ. Бээжинд шинжлэх ухаан техникийн мэдлэг маш ихээр төвлөрсөн, энд улс орны шинжлэх ухааны хамгийн том бааз, хамгийн нэртэй шинжлэх ухааны байгууллага, дээд сургууль, шинжлэх ухаан техникийн шилдэг ажилтнууд цугларсан газар юм. Сүүлийн жилүүдэд нарийн шинэ технологи боловсруулдаг салбарууд их хурдацтай хөгжиж. Тэдгээр нь нийт улс даяар цар хэмжээ, төвшний хувьд цөөхөн байгаагаас гол хүч нь байрладаг ЗХА-ийн бүс тэргүүн эгнээнд явж байна. Бээжин хот хятадын аж үйлдвэрийн баазын нэг бөгөөд түүний гол тулгуур нь хими, машин, хөнгөн ба нэхмэл, өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэл, бас хүнс, электроник, суудлын автомашин, эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг

* Тяньзин хотын эдийн засаг - Нийгмийн хөгжлийн судалгааны төвийн орлогч эрхлэгч

түлхүү хөгжүүлж байна. Бээжин нь гадаад худалдааны талаар 130 гаруй улс, бүс нутагтай, түм илүү үйлдвэр, худалдааныхантай худалдааны харилцаатай болоод байна. Бээжин бол Хятадын болон ЗХА-ийн зам харилцааны маш чухал зангилаа, дотооддоо хятадыг орон нутагтай гадагшаа ЗХА-тай холбодог чухал хот бөгөөд төмөр замаар ЗХУ, Монгол, Солонгостой холбогддог. Ялангуяа Бээжин-Тяньзиний өндөр хурдтай зам нээгдсэний дараа хоёр хотын зай эрс багассан билээ.

2. Тяньзин мөн өөрийн гэсэн давуу талуудтай. Үүнд:

2.1. Далайн эрэг дагуу оршдог, манай улсын хойд хэсгийн үйлдвэр, худалдааны томоохон төв, олон улсын чанартай боомт хот. Дотооддоо эдийн засгийн талаар харилцах цар хүрээ маш өргөн, гадагшаа бол өнөө үед, дэлхийн эдийн засгийн хамгийн эрчимтэй хөгжиж буй хэсэг болох Ази, Номхон далайн бүс ба ЗХА руу ханддаг.

2.2. Аж үйлдвэрийн бат бааз суурьтай, 120 жилийн өмнө үйлдвэрлэлээ эхэлсэн, манай аж үйлдвэрийн ууган баазын нэг юм.

2.3. Аж үйлдвэрийн маш олон салбартай тул хорших цогц байдлаар ашиглах бүрэн боломжтой.

2.4. Байгалийн баялгаар харьцангуй баян, нефть, байгалийн хий, нүүрсний нөөц ихтэй, далайн давс олборлох хамгийн том район хөрсөн доорх халуун нэлээд их талбайд тархсан, ойр орчимд нь далайн загас агнуурын бүс харьцангуй өргөн, аглаг уул, газрууд, далайн эрэг хавийг ашиглах боломж ихтэй.

2.5. Нэгэнт бүрэлдсэн оюуны потенциал, техникийн дорвитой баазтайгаас гадна техникийн зохих мэдлэг мэргэжил бүхий ихээхэн ажиллах хүчин бэлэн байна.

2.6. Нэлээд сайн дэд бүтцийг бий болгосон, зам харилцааны чухал сүлжээ, улсдаа хамгийн томд орох нисэх буудал, шуудан холбооны зэгсэн сайн техник тоног төхөөрөмжтэй.

Эндхийн хамгийн чухалчлан үзэх зүйл бол Тяньзиний далайн боомт, чөлөөт худалдааны бүс юм. Тяньзиний боомт бол 10 тэрбум долларын буюу улс орны гадаад худалдааны 1/10-ийг хийдэг, улсдаа хамгийн том нь юм. Тяньзиний боомт 50 гаруй зогсоолтойн 7 нь тусгай зориулалтын чингэлэгт ачааных бөгөөд хятадын энэ төрлийн зогсоолын хамгийн том нь юм. Тяньзин эдүгээ 160 гаруй улс, бүс нутгийн 300 боомттой худалдаа, бараа тээвэрлэлт хийж байна. 1991 оны V сард Төрийн Зөвлөлөөс Тяньзиний боомтыг худалдааны чөлөөт бүс болгон зарлаж тэнд эдийн засаг, хөгжлийн бүс байгуулахыг шийдвэрлэснээр шинэтгэл, нээлттэй бодлогын бас нэг шинэ «цонх» болж, улмаар эдийн засгийн онцгой бүс, эдийн засаг, техникийн хөгжлийн бүсээс илүү хурдан хөгжих, илүү давуу хөнгөлөлт үзүүлэх бодлого хэрэгжүүлэх ажээ. Чөлөөт бүсийг цаашдаа дэлхийн зах зээлтэй нягт холбох, олон улсын жишгийн дагуу тээвэрлэлт хийх, чөлөөт худалдааны бүсийн шинжтэй тусгай район болгон өөрчлөн байгуулна.

3. Монгол улстай хамтран ажиллахдаа Өвөр монголын Өөртөө засах орон Хэбэй мужтай холбоотойгоор тэдний давуу талыг ч бүрэн дайчлах хэрэгтэй. Өвөр Монгол нь улсын хойд хязгаарт орших бөгөөд өргөн уудам нутаг нь байгалийн баялгаар арвин, хүн амын нягтшил бага, нэг хүнд ноогдох тариалангийн талбай ихтэй. Гадагшаа хуучин нэрээр ЗХУ-тай 1100 км. Монгол улстай 3111 км газраар хиллэдэг. Ялангуяа хилийн Манжуур, Эрээн хотууд олон жил бүтээн босголт хийж, эдүгээ эх газрын чухал боомт, ЗХУ, Монгол, Дорнод Европт нэвтрэх хаалга болоод байна. Өвөр монгол нь Монгол, ЗХУ-тай эрт дээр үеэс хилийн худалдаа явуулж ирсэн уламжлалтай. Монгол, Өвөр Монгол хоёр үндэс угсаа, хэл нэгтэй, ах дүү найз нөхдийн харилцаа ихтэй. Монгол улс Өвөр монголын Хөх хотод консулын газар нээн ажиллуулж, харилцаа ихээхэн өргөжиж байна. Сүүлийн хоёр жилд

Монгол улсаас Өвөр монголд очсон төлөөлөгчид ихээхэн нэмэгдэж үйлдвэр байгуулахад туслалцахыг хүсэх болсон төдийгүй хамтарсан үйлдвэр аж ахуйн газар ч бий болоод байна. Өвөр Монгол дотооддоо хойд, зүүн хойд, баруун хойд хэсэгтэй зам тээврийн хувьд сайн холбогдсон. Ер нь улс орны аль ч хэсэгтэй хамтран ажиллах сайхан боломжтой юм. Тяньзинь хот Өвөр монгол руу эдийн засаг, техникийн шинжээчдийн бүлэг илгээж, зарим талаар хамтран ажиллах тохиролцоонд хүрээд байна. Тухайлбал, Өвөр Монгол Тяньзиний далайн боомт, чөлөөт бүс, эдийн засаг, техникийн хөгжлийн бүсийн давуу талыг ашиглах, хамтарсан үйлдвэр байгуулах, экспортод чиглэсэн эдийн засгийг хөгжүүлэх, гадаадаас хөрөнгө оруулж, дотоодынхонтой хамтран ажиллах 2 тийш чиглэсэн хамтын ажиллагаагаа хүчтэй болгохоор бэлтгэж байна. Иймд Өвөр Монголтой хоршин ажиллах өргөн ирээдүй байна. Эдгээр ашигтай хүчин зүйлүүдийг нэгтгэвэл бас нэг нэгдмэл давуу тал бүрэлдэх болно.

Хоёр. Монгол улсад үл тоомсорлож болох зах зээлийн потенциал байна

Монгол улс дэлхий дээр эх газрын хамгийн том орон бөгөөд газар нутаг нь 1 сая 566 мянган км² буюу Тяньзин шиг 142 хоттой дүйж байхад хүн ам нь Тяньзиний 1/4-тэй тэнцэхүйц 2,1 сая ажээ. Монгол нь байгалийн болон газрын доорх эрдэс баялгаар арвин, гол төлөв нүүрс, зэс, молибден, вольфрам, алт, төмөр, хар тугалга, хайлуур жонш, фосфор, давсаар баян. Байгалийн бэлчээр 124 сая га буюу дэлхийд 6 дугаар байрт орно. Нийт нутаг дэвсгэрийн 15 хувь буюу 235 мянган км² талбайг ой хөвч эзэлдэг. Монгол улс эртнээс мах аж ахуйг зонхилон эрхэлж байсан бөгөөд одоо ч улс ардын аж ахуйн суурь салбар хэвээр байна. 1991 онд малын тоо толгой 25,8 сая-д хүрч нэг хүнд оногдох талаараа Өвөр монголоос 7 дахин их, нэг хүнд оногдох тариалангийн талбай 10 гаруй му, (1 му = 0,05 га) үр тарианы хэрэгцээг үндсэндээ бие даан хангадаг. 1989 оны байдлаар Монголын хүн амын дундаж орлого 1300 доллар орчим байлаа. Монгол улс хөнгөн, хүнс, олборлох, түлш эрчим хүчний салбар зохих хэмжээнд хөгжсөн. Гадаад худалдаа бол Монголын эдийн засгийн амин судас, жилийн гадаад худалдааны нийт хэмжээ 2 тэрбум доллар буюу үндсэндээ Тяньзиний төвшинтэй тэнцүү гэсэн үг. Монгол улс 2000 гаруй нэр төрлийн бараа гаргаж, 60000 гаруйг оруулдаг. Монгол улсын нэг хүнд оногдох гадаад худалдааны хэмжээ Хятад улсынхаас 5—6 дахин их. Урт хугацааны турш ЗХУ-ыг түшсэний улмаас Монголын гадаад худалдааны 94 хувийг ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудтай хийж байв. Сүүлийн жилүүдэд ЗХУ, Дорнод Европын орнуудын байдал өөрчлөгдөн ЭЗХТЗ тарж, хуучин ЗХУ Монголд өгдөг байсан ихээхэн зээл тусламжаасаа татгалзсан билээ. Үүнтэй зэрэгцэн Монгол улсад шинэтгэл, нээлттэй бодлогын дуу хоолой өдрөөс өдөрт чангарч ирэв. Өрнөдийн орнууд саяхан нээгдсэн онгон нутгийг хараалан авсны дотор Япон эн тэргүүнд Монгол улсад нэн тааламжтай нөхцөл олгон, эдийн засгийн туслалцаа үзүүлж, хөрөнгө оруулж үйлдвэр байгуулах зэрэг хэд хэдэн арга хэмжээ удаа дараалан авч хэрэгжүүлж байна.

Одоогоор Хятад нь Монголоос зөвхөн мод, эмийн түүхий эд оруулж, хөвөн даавуу, торго, дурдан, хувцас, хөдөлмөрийн багаж, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, хүнсний зориулалттай ургамлын тос, жимс зэргийг гаргаж байна. Хятадаас Монголд экспортолсон бараа нь Монголын импортын дөнгөж 1,25 хувийг эзэлж байгаа нь Монголын зах зээл хичнээн их нөөц бололцоотойг харуулж байна. Монголын хүн ам цөөн, цалин Хятадынхаас өндөр оршин суугчдын худалдан авах чадвар сайтай боловч өргөн хэрэглээний бараа дутагдалтай байгаа юм.

Тяньзинаас нийлүүлсэн гурил хэдийнээ Монголын зах зээлд орж, эрэлт ихтэй байна. Хэрэв нөхцөл бололцоо бүрдвэл Монголд эрэлт хэрэгцээ ихтэй байгаа ургамлын тос, жимс, хүнсний ногоо зэрэг хүнсний шинэхэн бүтээгдэхүүн нийлүүлж, бас хими, машин, нэхмэл, хувцас, эм болон хөнгөн үйлдвэрийн бусад бүтээгдэхүүн, барилга, үйлдвэрлэлийн хэрэгслийн зах зээлийг ч эндээс олж болно. Монгол улсын гадаад худалдаа урт хугацааны турш алдагдалтай байсан тул энэ байдлаа засахын тулд тэд экспортоо нэмэгдүүлэхийг эрмэлзэж байна. Гэвч Монгол улс олон жил хуучин ЗХУ-аас үйлдвэрлэлийн хэрэгсэл дээр ч, ахуйн хэрэглээний бараан дээр ч хараат байсан, эд бүгдийг гол төлөв бод, бог мал, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, мод, өнгөт төмөрлөгийн зүйлээр сольж авдаг байлаа. Энэ нь боловсруулах үйлдвэр бүхий Тяньзин хотын хувьд түүхий эдийн эх сурвалжаа нэмэгдүүлнэ гэсэн үг юм.

Гурав. Үйлдвэрлэлийн бүтцээ харилцан дорвитой нөхөн сэлбэх шинж

Үйлдвэрлэлийн салбарын талаас авч үзвэл Монголд I салбарын үйлдвэрлэл зонхилж байхад Бээжин, Тяньзин II салбарын үйлдвэрлэл голлосон тул бие биенээ нөхөх шинж илт харагдаж байна. Үйлдвэрлэлийн бүтцийн хувьд Тяньзинд бүхий л чиглэлийн үйлдвэрийн газрууд бий бөгөөд дунд, жижиг үйлдвэрүүд олон байгаа нь Монгол улсын гаднаас хөрөнгө, техник оруулах сонирхол, жижиг, дунд үйлдвэр байгуулах эрэлт шаардлагад яв цав нийцэж байна. Бээжин ч гэсэн хүнс, нэхмэл, машин, хими, өргөн хэрэглээний бараа экспортлох техникийн талаар хамтран ажиллах арга замыг идэвхтэй эрж хайж байна. Сүүлийн жилүүдэд Монголын засгийн газар бодит байдлыг үндэслэн уламжлалт мал аж ахуйн давуу талыг хадгалан хөгжүүлээд зогсохгүй орчин үеийн аж үйлдвэрийг түлхүү хөгжүүлэн, мал аж ахуйн түүхий эд экспортлох орноос мал аж ахуйн гаралтай аж үйлдвэрийн бүтээгдэхүүн экспортлогч орон болгох хэрэгтэй хэмээн онцлон үзэх болов. 1990 онд Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж, олон улсын хөдөлмөрийн хуваарь, дэлхийн эдийн засгийн системд оролцохын чухлыг тэмдэглээд, гадаадын хөрөнгө, техник оруулах ялангуяа Хятад, Японтой хамтран ажиллахыг гойд чухалчлан үзэж байна. Энэ бол бидэнд үйлдвэрлэлийн бүтцийн зохицуулалтаа гадагш чиглэсэн эдийн засгийг хөгжүүлэхтэй хослуулах түлхүүр ч болж мэдэх юм. Юуны өмнө зохицуулалт хийгдэх уламжлалт үйлдвэрлэлүүдээ мөн түүнчлэн Монголын эрэлт хэрэгцээнд нийцэх техник, тоног төхөөрөмжийг шилжүүлэн аваачиж, үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн үр нөлөөг дайчлах хэрэгтэй. Хоёрдугаарт, Монголын эрэлт шаардлагыг үндэслэн хүчин чадал, нөхцөл бололцоо бүхий үйлдвэрүүдийг нөгөө талд зоригтой шилжүүлэх, түүхий эдийн анхан шатны, улмаар гүнзгий боловсруулалт хийх хэрэгтэй. Гуравдугаарт, техникийн экспортыг нэмэгдүүлэх шаардлагатай. Боловсронгуй техник болон шинэхэн үеийн техникийн аль аль талаар Бээжин, Тяньзин хоёулаа давуу талуудтай, харин гол зангилаа бол техникийн үе шатанд, өөрөөр хэлбэл техник нь үе шатны хувьд доогуур зохистой түншийг л олох хэрэгтэй. Тэгвэл бараг бүгд экспортын потенциалтай байдаг. Техникийн экспорт бас тоног төхөөрөмж, ажиллах хүч, түүхий эд экспортлох ашигтай нөхцөлийг бүрдүүлдэг. Эдийн засгийг техниктэй хослуулбал худалдааг аль болох хурдан хөгжүүлэх түлхэц болдог. Түүнээс гадна Бээжин, Тяньзинд байдлыг харгалзан Монголд олон талын боловсон хүчнийг бэлтгэхэд тусламж болох юм.

**Дөрөв. Монгол улстай хамтын ажиллагааг
өрнүүлж Тяньзиний зам тээврийг
улам хөгжүүлэе**

Эх газрын улс болох Монгол далайд гарц олох нэн шаардлагатай, тэгээд ч Тяньзин түүний хувьд хамгийн чухал объект юм. Тяньзиний боомт Евразийн эх газрыг хамгийн дөтөөр холбох гүүрийн ам, Монгол, хуучин ЗХУ, Дорнод болон Өрнөд Европ руу хийх тээврийн гол шугам юм. Бараа таваарын тээвэрлэлтэд Тяньзин нь маш чухал «гүүр»-ийн үүрэг ч гүйцэтгэж болох талтай. Монгол улс урьд гол төлөв хуучин ЗХУ-ын Алс Дорнодын боомтоор дамжуулан экспорт, импортын бараагаа тээвэрлэж байлаа. 1989 оноос Тяньзиний боомт худалдааны чөлөөт агуулах, Монголтой хамгийн ойр дөт оршдог газар зүйн давуу талаа ашиглан Хятадад анх удаа Монголын төмөр замаар транзит тээврийг туршин хийж эхэлсэн. Монголын тал ч транзит тээврийн чанарт сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн билээ.

Экспортод чиглэсэн эдийн засгийг хөгжүүлэх явдал Тяньзиний тээврийг хөгжүүлэх чухал хөшүүрэг юм. Үүний үндэслэл гэвэл, юуны өмнө Тяньзиний боомт аль болох эрт Монголын далайд гарах гарц болж чадвал боомтоос олох ашгийг хэд дахин нэмэгдүүлж, түүнийг улам цэцэглүүлэн хөгжүүлж болох юм. Хоёрдугаарт, Монголд далайн гарц олговол Монголоос тээвэрлэх их хэмжээний бараа таваар тээврийн бас нэг томоохон зах зээлийг зайлшгүй бий болгож, тэр нь зам тээврийн салбарыг хөгжүүлэхэд маш их үр ашиг өгнө. Гуравдугаарт, худалдааны хэмжээ нэмэгдэхийн хэрээр үнэ цэнэтэй, амархан гэмтэх эсвэл түр хөлдөөн тээвэрлэх бүтээгдэхүүнийг авто зам, агаараар тээвэрлэх давуу талаа ч нээн илрүүлж, тээвэр, худалдааг хоршин байж ашиг олж болох юм. Дөрөвдүгээрт, Монгол улсыг гол объект болгон олон улсын зам тээврийн бааз суурийг байгуулж, цаашдаа нөхцөл бололцоо бүрдүүлсний дараа Монголыг дамжин хуучин ЗХУ, Дорнод болон Өрнөд Европт хүрэх төмөр замын тээвэр нээж болно. Тавдугаарт, Тяньзин Тээврийн суваг болж буй давуу талаа ашиглан гадаадын хөрөнгө оруулж зам тээврийг хамтран хөгжүүлэх нь Тяньзиний ирээдүйн хөгжилд алс хэтийн чухал ач холбогдолтой.

**Тав. Монгол улстай хамтын ажиллагааг
хөгжүүлэх цаг үе бүрдээд байна**

Монгол улс гадаад харилцаагаа өргөжүүлэн эдийн засгийн хөгжилдөө түлхэц өгөх эрмэлзэл эн тэргүүний тулгамдсан зүйл болоод байна. Монгол нь хуучин ЗХУ-д асар их өртэй учир арга буюу нээлттэй бодлогын алхмаа түргэтгээд зогсохгүй олон талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлэхийг чармайж байна. Үүнд нийцүүлэн Монгол улс гадаад бодлогын чиг шугамдаа идэвхтэй зохицуулалт хийсээр байна. Нэгдүгээрт, урьд дан ганц хуучин ЗХУ-ыг түших арга барилаа өөрчилж, хоёр том хөрш Хятад, ЗХУ-тай харилцааг бvх талаар хөгжүүлэх явдлыг Монголын гадаад харилцааны эн тэргүүний зорилт болгов. Хоёрдугаарт, эвсэлд үл нэгдэх бодлого баримтлах, 77-гийн бүлэгт элсэн орж, «Дорнын Швейцарь» болохыг чармайж байна. Гуравдугаарт, өөрийгөө Ази, Номхон далайн орон хэмээн үзэж тус бүсийн орнууд, бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх арга замыг идэвхийлэн эрэн сүвэгчилж байна. 1989 онд ЕЭЗХН-тэй дипломат харилцаа тогтоосны дараа, 1990 онд Японтой Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээр байгуулж, Өмнөд Солонгостой элчин сайдын хэмжээнд дипломат харилцаа тогтоосноос гадна Азийн хөгжлийн банкинд элсэн оров. Дөрөвдүгээрт, үүд хаалгаа өргөнөөр нээж, гадаадын хөрөнгө оруулж эхлэв. Монгол энэ талаар нэ-

лээд дориун бодлого боловсруулаад байна. 1988 онд «Социалист орнуудтай хамтран хөрөнгө оруулсан үйлдвэр аж ахуйн газрын хууль» баталсан. Өнгөрсөн оноос «хөгжиж буй орнуудаас хамгийн том хэмжээний гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль» хүчин төгөлдөр болсон бөгөөд уг хуулиар гадаадын хөрөнгө оруулагч Монголын улсын үйлдвэр, хувь хүнтэй хөрөнгө хамтрах, эсвэл бие даан үйлдвэр байгуулахыг зөвшөөрчээ. Үйлдвэрлэл явуулж эхэлсэн эхний 3 жилд татвараас чөлөөлөгдөж, олсон цэвэр орлогоо гадагш авч гарахыг хязгаарлаагүй ажээ. Япон, Англи, АНУ, Австри зэрэг орнууд Монголд хөрөнгө оруулж үйлдвэр байгуулсан буюу байгуулахаар бэлтгэж байна. Монгол эдүгээ Өрнөдийн 20 гаруй орны 200-гаад худалдааны компанитай ажил төрлийн харилцаа тогтоогоод байна. Тэд нэлээд орноос хөрөнгө, тэргүүний техник оруулж, ямаа, тэмээний ноолуур боловсруулж, ноосон нэхмэл үйлдвэрлэх, мөн түүнчлэн гадаадтай хамтран нефть, нүүрс олборлох талаар хэлэлцээр хийж байна.

Хятад, Монголын найрсаг харилцаа урт хугацааны турш хөгжих тул энэ нь хоёр орны эдийн засаг, техникийн хамтын ажиллагаанд олон улсын таатай нөхцөл бүрдүүлж байгаа юм. 1991 оны VШ сард Ян Шанкунь дарга Монгол улсад төрийн айлчлал амжилттай хийж хоёр орны Засгийн газрын хооронд хэд хэдэн хэлэлцээр байгуулсан билээ. Монгол улс урьд хуучин ЗХУ-руу дагнасан гадаад бодлогоо өөрчлөх явцдаа Хятад улстай ойртох, түүнээс тусламж дэмжлэг авахыг идэвхтэй чармайж буйд бодит эрэлт шаардлага байна. Нэгдүгээрт, Хятадын боомтыг далайд гарах гарц болгон ашиглавал Ази, Номхон далайн орнуудтай эдийн засгийн харилцаа тогтооход хамгийн дөт замаар холбогдох учраас Тяньзин нь Монголын сонирхлыг хамгийн их татаж байна. Энэ нь Тяньзин, Улаанбаатартай эдийн засаг, техник, худалдааны хамт ажиллагаагаа бүх талаар хөгжүүлэхэд хүчирхэг хөдөлгөгч хүч болно гэсэн үг. Хоёрдугаарт, хятадын өргөн хэрэгцээний бараа авахыг эрмэлзэж байна. Монголын гадаад худалдааны 80 хувийг эзэлж байсан хуучин ЗХУ-ын үйлдвэрлэл буурч, өргөн хэрэгцээний бараа дутагдаж, Зөвлөлт өөрөө ч хүнд байдалд орохын хамт Монгол арга буюу худалдааны сувгаа нэмэгдүүлж зайлшгүй хэрэгцээт өргөн хэрэглээний барааны импортыг баталгаатай болгох хэрэгтэй болсон билээ. Энэхүү тохиромжтой үед Монголд ЭЗХТЗ-ийн орнуудын эзэлж байсан байр суурийг аажмаар олж авах боломж бүрдээд байна.

Хятад, Монгол хоёр орны худалдааны харилцаа хөгжлийн шинэ шатанд ороод байна. Хоёр орны харилцаа хэвийн болсонтой уялдан, худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техник, соёлын салбарт хамтын ажиллагаа тасралтгүй өргөжиж байна. 1990 оны Ш сард Улаанбаатар хотноо Хятад, Монголын Засгийн газар хоорондын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн талаар хамтран ажиллах комиссын анхны хуралдаан болж Монголтой хамтран коксжих нүүрс, төмрийн хүдэр олборлох, шүдний оо, сайн чанарын вааран хавтанцарын үйлдвэр хоршин байгуулах хэлэлцээр байгуулж, хоёр улсын яам, хороо, муж, хот, ӨЗО болон гадаад харилцааны эрх бүхий байгууллагуудын шууд харилцааг хөхүүлэн дэмжихээр тохиролцсон юм. Энэ нь манай хот Монголын яам, орон нутагтай хамтран ажиллах харилцаа холбоо тогтоох замыг нээлээ. Үүний зэрэгцээ Монгол улс чөлөөт валютаар худалдаа хийхээр шийдвэрлэсэн явдал Монголтой худалдаа хөгжүүлэх таатай нөхцөл бүрдүүлээ.

Хятадын «Зүүн хойд Азийн индэр»
сэтгүүлийн 1992 оны № 2-оос
орчуулсан Д. Шүрхүү